

## “МОНГОЛЫН ОРЧИН ҮЕИЙН ТҮҮХ” НОМ ЯПОНЫ УНШИГЧДЫН ГАРТ ОЧЛОО

*Э.Сарантогос\**

Түүхийн шинжлэх ухааны доктор, судлаач Ц.Батбаярын “Монголын орчин үеийн түүх” /Монгору гэндайши/ ном япон хэлнээ Олон улсын монголч эрдэмтний VIII их хурлын өмнө хэвлэгдэн гарав. Уг номыг Японы Хитоцүбаши Их Сургуулийн хүндэт профессор, нэрт монгол судлаач, эрдэмтэн Танака Кацүхико залуу судлаач Ашимура Такашийн хамтаар хянан орчуулж, Акаши хэвлэлийн газарт хэвлэжээ.

Монголын түүх судлалын тухай Японы монгол судлаач, эрдэмтэд олон сайхан бүтээл туурвиж, манай орны түүх судлалд чухал хувь нэмэр оруулж ирснийг бид мэднэ. Харин Монголын түүхийг сонирхдог японы нийт уншигчдад зориулан бичигдсэн энэхүү номын онцлог нь монголчуудын түүхийг монгол хүний нүдээр харах бололцоог япончуудад олгосонд оршиж байгаа юм.

Энэ номыг уншсанаар япончууд XX дугаар зууны эхэн үеэс 1990-ээд оны ардчилсан хувьсгал хүртэлх манай шинэ үеийн түүхийн талаар бодит ойлголттой болж үлдэхийн сацуу дэлхийн II дугаар дайнаас хойшхи үеийн Монгол, Японы харилцааны хөгжлийн талаар тодорхой мэдлэгтэй болох юм.

“Монгол орон өнөөгийн тусгаар тогтнолыг олж авахын тулд ямар хүндрэл бэрхшээлийг гэтлэн давж ирснийг өгүүлэхдээ хамгийн гол гол үйл явдлыг товч бөгөөд тодорхой бичжээ. Харахад зузаан ном биш боловч Монголын түүхийн тухай олон зуун хуудастай ном уншснаас дутахааргүй их мэдлэг олж авахаас гадна судлаачийн өөрийн өвөрмөц үзэл бодлыг уншиж мэдэх боломжтой” хэмээн уг номын талаар К.Танака гуай өгүүлжээ.

Ном хоёр хэсэгтэй. “XX зууны Монголын түүх” хэмээх хэсгийн эхний бүлэгт XX зуунаас өмнөх үеийн Монголын түүхийг тоймлон бичжээ. Эзэн Чингисийн үед монголчууд хүчирхэг гүрэн байгуулж, Солонгосын хойгоос Унгарыг хүртэлх өргөн удам нутагт эзэрхэн суусан. Харин XIV зууны дунд үеэс Монголын Эзэнт гүрэн хагаран бутрах эхлэл тавигдаж, улмаар 1636 онд Өвөр Монгол, 1691 онд Халх Монгол Манжийн хааны ноёрхолд орсон. XVI зууны сүүлчээр Өвөр Монголын Алтан хаан Түвдээс буддын шашны шар малгайтны

\*Э.Сарантогос - ГХЯ-ны ажилтан

урсгалыг анх Монголд нэвтрүүлсэн. Буддын шашны ном сургааль нь нүүдэлчин монголчуудын соёл, зан заншил, нийгмийн сэтгэхүйд ихээхэн нөлөөлснөөс гадна лам хуврага хэмээх нийгмийн цоо шинэ давхаргыг бий болгосон тухай энд өгүүлжээ.

Зохиогч номдоо япончуудын олонтаа асуудаг зарим ярвигтай асуултад хариу өгчээ. Тухайлбал, “Манжийн ноёрхол Монголд 200 гаруй жил үргэлжилсэн бөгөөд энэ хугацаанд монголчууд яагаад хятаджаагүй вэ” гэдэг асуудал гадныхан, тэр дотроо япончуудын сонирхлыг татдаг. Зохиогч энэ талаар дурьдахдаа “үүнд соёл, шашны хүчин зүйл хүчтэй нөлөөлсөн. Монголчууд өөрсдийгээ Төвдийн бурхны шашныг эрхэмлэгчид гэж үзэж ирсэн тул соёлд нь Күнзийн сургааль нэвтрээгүй. Мөн түүнчлэн манжууд монголчуудтай хүчтэй эвсэл байгуулах сонирхолтой байсны улмаас Монголд Хятадын нөлөөг нэвтрүүлэхгүйн үүднээс хууль тогтоомж хүртэл гаргаж байв. Тухайлбал, Монголын хилээр нэвтрэн орж ирэх, Монголд тариа тарих, монгол эмэгтэйтэй гэрлэхийг хориглодог байсан” хэмээн бичжээ.

Зохиогч номынхоо нэгдүгээр хэсгийг XX зууны Монголын шинэ үеийн түүхийг бичихэд зориулжээ. 1911 оны Монголын тусгаар тогтнолын төлөө тэмцэл, Монголд нөлөөгөө нэмэгдүүлэх гэсэн Орос, Хятадын бодлого, 1921 оны Ардын хувьсгал, 1924 онд Үндсэн хууль батлагдаж БНМАУ байгуулагдсан тухай, мөн ЗХУ-ын нөлөө хэрхэн ихсэж байсан тухай, Монголыг бамбай улс болгох гэсэн Сталины геостратегийн бодлого, их гүрний өрсөлдөөн дунд тусгаар тогтнолоо хамгаалж үлдэх гэсэн монголчуудын хүсэл эрмэлзлэл, 1937 оны хэлмэгдүүлэлтийн их шуурга, Х.Чойбалсан, Ю.Цэдэнбал зэрэг удирдагчдын тухай зохиогч японы уншигчдад толилуулжээ. Зохиогч эдгээр асуудалд үзэл сурталжсан байр сууринаас биш үндэсний эрх ашгийн үүднээс хандаж, судлаачийн өөрийн өвөрмөц тайлал гаргалгааг хийсэн байна.

1990 оны ардчилсан хувьсгалыг тайван замаар хэрэгжүүлэхэд, зохиогчийн үзэж байгаагаар хэд хэдэн хүчин зүйл нөлөөлжээ. “Гадна талаасаа 1980-аад оны үед ЗХУ-д өрнөсөн “перестройка”, Дорнод Европын орнуудад өрнөж байсан ардчилсан хөдөлгөөн үүнд нөлөөлсөн. Мөн тэр үед Монголын удирдагчдын нийгэм, эдийн засгийн салбарт хэрэгжүүлж байсан аядуу хүлцэнгүй бодлого амжилтад хүрэлгүй эдийн засаг нь хүнд байдалд орсноос Монгол оронд өөрчлөлт шинэчлэл хийх бодит шаардлага тулгарч байв. Улс төрийн өөрчлөлт шинэчлэл хийхийг хүчтэй шаардагсдын

ихэнх нь ЗХУ, Дорнод Европын орнуудад боловсрол эзэмшсэн шинэ үеийнхэн байлаа. Цэрэг цагдаа үүнд огт оролцоогүй гэдгийг дурдах нь зүйтэй...” гэжээ. 1990 оноос ардчилсан хувьгал ялснаар монголчууд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх болсон. Уламжлалт соёл, шашин шүтлэг дахин сэргэж, дэлхийн түүхэнд нэр алдраа дуурсган үлдээсэн Чингис хааныг монголчууд дахин шинээр үнэлэх болсон тухай мөн дурьджээ.

Номын хоёрдугаар хэсэгт Монгол, Японы хооронд дипломат харилцаа тогтсон үеэс эхлэн эдүгээ хоёр орны харилцаа бүхий л салбарт амжилттай хөгжиж байгааг дурьдаад Японоос Монголд үзүүлж буй зээл тусламжийн талаар уншигчдад тодорхой мэдээлэл өгсөн байна. Зохиогч Монгол улсын Гадаад харилцааны архивын арвин баримт сэлт дээр тулгуурлан Монгол –Японы хооронд 1972 онд дипломат харилцаа тогтоохын төлөө хоёр орны олон нийт, соёл шинжлэх ухааны зүтгэлтнүүд, Парламентын гишүүд, дипломатуудын гаргасан уйгагүй хүчин зүтгэл, ярвиг төвөгтэй хэлэлцээ ярианы үүх түүхийг нарийн нягт задлан шинжилсэн байна.

Японы уншигчдад Монголын түүхийг монгол хүний нүдээр харах, дүгнэх боломж олгосон судлаач, доктор Ц.Батбаяр Монголыг сонирхож буй олон япон хүний таашаал, талархлыг хүлээх нь дамжиггүй.